



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монголросцветмет” ХХК-ийн 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 2,389.6 (хоёр тэрбум гурван зуун наян есөн мянга зургаан зуун) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Монголросцветмет” ХХК-ийн 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Монголросцветмет” ХХК-ийн ерөнхий захирал Д.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;

2.2.Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргаж ажилласан үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нартай хөдөлмөрийн болон контрактын гэрээг дуусгавар болгох хүртэл хариуцлага тооцох;

2.3.Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, хугацаа хэтэрсэн авлагыг хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

2.4.Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийг худалдах болон шилжүүлэх асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.5.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дугаар сарын 03-ний өдрийн  
8.7 дугаар тогтоолын хавсралт



“Монголросцветмет” ХХК-ийн 2017 оны шалгалтаар илэрсэн зөрчил,  
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Дүн /сая төгрөг/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.8 дахь хэсэгт заасныг зөрчиж найдваргүй авлага бий болгосон	Ерөнхий захирал, дэд захирал, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	62.0	Найдваргүй авлага үүсгэхгүй байх, 1 жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19, 33, 44, 46, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Ерөнхий захирал, Үнэлгээний хорооны гишүүд, Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ажиллагсад	2,327.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, төлөвлөгөөг хуулийн хугацаанд ил тод нээлттэй мэдээлэх, харьцуулалтын аргыг хэрэглэх, жишиг баримт бичиг ашиглах, урьдчилгаа төлбөрийг нөхцөл шаардлагын дагуу өгөх.
<b>Зөрчил, дутагдлын нийт дүн</b>			<b>2,389.6</b>	